

“Таван Богд Финанс ББСБ” ХХК

Дотоод хэрэгцээнд

“Таван Богд Финанс ББСБ” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн  
2024 оны 07 сарын 09-ний өдрийн 14/14 тоот тогтоолын хавсралт № 1.



## СОНИРХЛЫН ЗӨРЧИЛТЭЙ ХЭЛЦЭЛ БАЙГУУЛАХ ЖУРАМ

Улаанбаатар хот  
2024 он

**ӨӨРЧЛӨЛТИЙН ТҮҮХ**

**Баримтын нэр:** Сонирхлын зөрчилтэй хэлцэл байгуулах журам  
**Хувилбарын дугаар:** ТБФ\_1.0  
**Анх боловсруулсан огноо:** 2024 оны 7 дугаар сарын 09-ний өдөр  
**Ангилал:** Дотоод хэрэгцээнд

**Боловсруулсан:**

№	Ажилтны нэр	Албан тушаал	Баримт бичгийн хадгалалт	
			ТУЗ-ийн нарийн бичгийн дарга	Бусад
1.	Г.Ганзул	Хуульч	Эх хувь Нийт 8 хуудас	
2.	Т.Амгаланбаатар	ЭУА-ны дарга		

**Өөрчлөлтийн түүх:**

Хувилбарын дугаар	Тушаалын дугаар, огноо	Байршил / Хавтас, IP хаяг/	Тайлбар
1.0	2024.07.09	Эх хувь	Анхны төсөл
	ТБЗ 42/24-12		


**АГУУЛГА**

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ.....	4
ХОЁР. СОНИРХЛЫН ЗӨРЧИЛТЭЙ ХЭЛЦЭЛ .....	5
ГУРАВ. СОНИРХЛЫН ЗӨРЧИЛТЭЙ ХЭЛЦЭЛ ХИЙХ ҮЙЛ АЖИЛЛАГАА.....	5
ДӨРӨВ. БҮРТГЭЛ, ТАЙЛАГНАЛТ .....	6
ТАВ. ХАРИУЦЛАГА .....	6

## СОНИРХЛЫН ЗӨРЧИЛТЭЙ ХЭЛЦЭЛ БАЙГУУЛАХ ЖУРАМ

### НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 **Журмын зорилго:** Энэхүү журмын зорилго нь “Таван Богд Финанс ББСБ” ХХК-ийн сонирхлын зөрчилтэй этгээдүүдтэй Компанийн тухай хуулийн 12 дугаар бүлэгт заасан сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх, сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэхтэй холбоотой харилцааг зохицуулахад оршино.
- 1.2 **Товчилсон үг, Нэр томъёоны тайлбар:**
  - 1.2.1 ББСБ - Таван Богд Финанс ББСБ ХХК;
  - 1.2.2 Толгой компани - Таван Богд Холдингс ХХК;
  - 1.2.3 Групп компани - Таван Богд Холдингс ХХК-ийн хараат болон охин компаниуд
  - 1.2.4 ТУЗ -ББСБ-ын Төлөөлөн удирдах зөвлөл;
  - 1.2.5 Удирдлагын баг – Ерөнхий болон Гүйцэтгэх захирал, дэд захирал болон менежмент багийн гишүүд;
  - 1.2.6 **“Ашиг сонирхлын зөрчил”** гэж Толгой компанийн болон ББСБ-ын эрх бүхий албан тушаалтнууд, ажилтан ажил үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон түүнтэй хамаарал бүхий этгээдийн зүгээс нөлөөлж болохуйц эдийн болон эдийн бус ашиг сонирхлыг;
  - 1.2.7 **“Сонирхлын зөрчил бүхий этгээд”** гэж дараах этгээдүүдийг хэлнэ.



- 1.2.7.1 ББСБ-ын Удирдлагын багийн гишүүд, тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээд;
- 1.2.7.2 ББСБ-ын ТУЗ-ын гишүүд, тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээд;
- 1.2.7.3 ББСБ-ын хорин хувиас дээш хувийг эзэмшиж буй өмчлөгчид, тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээд;
- 1.2.7.4 Толгой компанийн менежмент багийн гишүүд, тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээд;
- 1.2.7.5 Таван Богд Холдингс ХХК-ийн хараат болон охин компаниуд, тэдгээрийн гүйцэтгэх удирдлагууд, тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээд
- 1.2.8 **“Сонирхлын зөрчилтэй хэлцэл”** Сонирхлын зөрчил бүхий этгээд нь ББСБ-тэй хийж байгаа хэлцлийг сонирхлын зөрчилтэй хэлцэл гэнэ.
- 1.2.9 **“Нэгдмэл сонирхол бүхий этгээд”** гэж тухайн ажилтан, албан тушаалтны ашгийн төлөө болон ашгийн бус үйл ажиллагаагаар холбоотой хувь хүн, хуулийн этгээд болон Компанийн тухай хуулийн 89 дүгээр зүйлд заасныг;
- 1.2.10 **“Эрх бүхий албан тушаалтан”** гэж ББСБ-ын Хувьцаа эзэмшигчид, Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүд, Удирдлагын баг зэрэг компанийн албан ёсны

шийдвэрийг гаргахад болон гэрээ хэлцэл хийхэд шууд болон шууд бусаар оролцдог этгээдийг тооцно.

## **ХОЁР. СОНИРХЛЫН ЗӨРЧИЛТЭЙ ХЭЛЦЭЛ**

- 2.1 Доор дурдсан харилцааг сонирхлын зөрчилтэй хэлцэлд тооцно.
  - 2.1.1 Сонирхлын зөрчилтэй этгээд нь хэлцлийн нөгөө тал, эсхүл зуучлагчаар оролцож байгаа;
  - 2.1.2 Сонирхлын зөрчилтэй этгээд нь Хэлцлийн нөгөө тал, эсхүл зуучлагчаар оролцож байгаа хуулийн этгээдийн толгой компанийн албан тушаалтан, эсхүл энгийн хувьцааны 20-оос дээш хувийг дангаараа болон нэгдмэл сонирхолтой этгээдтэйгээ хамтран эзэмшиж байгаа;
  - 2.1.3 Сонирхлын зөрчилтэй этгээд нь хэлцлийн үр дүнд шууд буюу шууд бусаар үүсэх орлогоос хувь хүртэж байгаа;
- 2.2 Дараах тохиолдолд сонирхлын зөрчилтэй хэлцэлд үл хамаарна.
  - 2.2.1 Хувьцаа эзэмшигч нь Компанийн тухай хуулийн 38 дугаар зүйлд заасны дагуу хувьцаа худалдан авах эрхээ хэрэгжүүлэх;
  - 2.2.2 ББСБ нь хувьцаа эзэмшигч тус бүрээс тэдний худалдахаар санал болгож байгаа хувьцааг санал болгосон нийт хувьцааны төрөл тус бүрийн тоотой хувь тэнцүүлэн худалдан авах;
  - 2.2.3 Толгой компани хувьцаагаа эргүүлэн худалдаж авах;
  - 2.2.4 Толгой компаниас дүрмийн сан нэмэгдүүлэх;
  - 2.2.5 Группийг нэгтгэх хэлбэрээр өөрчлөн байгуулагдсан;
  - 2.2.6 Хувьцааг тэргүүн ээлжид худалдаж авах эрхээ хэрэгжүүлэх;
  - 2.2.7 ББСБ-ын дотоод журам, ерөнхий нөхцөлийн дагуу олгох зээлийн гэрээ;
  - 2.2.8 ББСБ-ын дотоод журам, ерөнхий нөхцөлийн дагуу байгуулах Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ;
  - 2.2.9 Өрийн хэрэгсэл худалдах гэрээ;
  - 2.2.10 ББСБ-ын үндсэн үйл ажиллагааны хүрээнд толгой болон групп компани хооронд хийгдэх хамтран ажиллах гэрээ, түрээсийн гэрээ, батлагдсан төсвийн дагуу хийх худалдах, худалдан авах гэрээ;

## **ГУРАВ. СОНИРХЛЫН ЗӨРЧИЛТЭЙ ХЭЛЦЭЛ ХИЙХ ҮЙЛ АЖИЛЛАГАА**

- 3.1 ББСБ нь журмын 2.1 дүгээр зүйлд заасан сонирхлын зөрчилтэй хэлцлийг ТУЗ-өөр хэлэлцүүлж шийдвэрлүүлнэ.
- 3.2 Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүн нь тус хэлцэлд сонирхлын зөрчилтэй тохиолдолд бусад гишүүдийн олонхын саналаар шийдвэрлэнэ.
- 3.3 Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх тухай асуудлыг ТУЗ шийдвэрлэж чадаагүй нөхцөлд хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулах тухай шийдвэрийг ТУЗ-ийн гишүүдийн олонхын саналаар гаргана.
- 3.4 Журмын 3.3-д заасан нөхцөлд Хувьцаа эзэмшигчдийн хурлаар сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх эсэхийг хэлэлцэж шийдвэрлэнэ.
- 3.5 Сонирхлын зөрчилтэй этгээдүүд нь хувийн ашиг сонирхлын үүднээс шийдвэр гаргах, дүгнэлт гаргах үйл ажиллагаа явуулах, баримт бичгийн төсөл боловсруулах, төлөвлөх,

- хянах, гэрээ хэлцэл байгуулахад саад учруулах, зүй бусаар нөлөөлөх зэргээр Компанийн хууль ёсны ашиг сонирхолд харшилсан үйлдэл, эс үйлдэхүй хийхээс зайлсхийнэ.
- 3.6 Сонирхлын зөрчилтэй этгээдүүд нь өөрийн албан тушаалын эрх мэдэл, чиг үүргийн хүрээнд шийдвэр гаргах, хяналт шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах эдгээрийг хэлэлцэх зэрэгт оролцохдоо “Нэгдмэл сонирхолтой этгээдийн мэдүүлгийн маягт” Хавсралт №1-ийг бөглөж, баталгаажуулсан байх бөгөөд өөрчлөлт орсон тохиолдолд тухай бүр маягтыг шинэчилж бөглөх үүрэгтэй.
- 3.7 Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх тухай бүрд доор дурдсан нөхцөл үүссэнийг “Сонирхлын зөрчил мэдэгдэх хуудас” Хавсралт №2-ыг бөглөн баталгаажуулж, гүйцэтгэх удирдлагад хүргүүлнэ.
- 3.7.1 Дангаараа болон нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран энгийн хувьцааны 20 буюу түүнээс дээш хувийг эзэмшдэг хуулийн этгээдийн болон түүний хараат болон охин компанийн талаар;
- 3.7.2 ББСБ-ын хийхээр төлөвлөж байгаа хэлцлийн сонирхол бүхий этгээд болох тухайгаа;
- 3.7.3 Компанийн хуулийн 89.1-д заасан этгээд өөрийн нэгдмэл сонирхолтой этгээдийн талаар.
- 3.8 Сонирхлын зөрчилтэй этгээдүүдэд нь өөрийн болон өөрт хамаарал бүхий этгээд, нэгдмэл сонирхол бүхий этгээдийн хувийн ашиг сонирхолд нийцүүлэх бизнесийн шийдвэр гаргах, өөрийн албан тушаалын байдлаа ашиглан бусад ажилтнуудад даалгах, хөндлөнгөөс нөлөө үзүүлэхийг хориглоно.
- 3.9 Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх этгээд нь уг хэлцлийн талаар шийдвэр гаргахад оролцохгүй.

#### **ДӨРӨВ. БҮРТГЭЛ, ТАЙЛАГНАЛТ**

- 4.1 ББСБ нь суурь системээр дамжуулан сонирхлын зөрчилтэй хэлцлийг бүртгэх ажлыг зохион байгуулахаар зорьж ажиллана.
- 4.2 ББСБ-ын ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь Сонирхлын зөрчилтэй хэлцлийг бүртгэх, ТУЗ-д тайлагнах, шаардлагатай тохиолдолд эрх бүхий байгууллагад хүргүүлэх ажлыг хариуцна.

#### **ТАВ. ХАРИУЦЛАГА**

- 5.1 Энэхүү журмыг зөрчсөн этгээдэд Компанийн тухай хуулийн 93 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээлгэх бөгөөд компанид учирсан хохирлыг буруутай этгээд хариуцна.
- 5.2 Сонирхлын зөрчил бүхий этгээд нь компанид учруулсан хохирлын хэмжээгээр эсхүл хэлцлийн үр дүнд авсан зүйлээс олсон ашгийн хэмжээгээр хариуцлага хүлээж, гэм буруутай этгээд өөрийн хөрөнгөөр нөхөн төлнө.

“Таван Богд Финанс ББСБ” ХХК-ийн 2024 оны 07 сарын 09-ний өдрийн  
“Сонирхлын зөрчилтэй хэлцэл байгуулах журам”-ын Хавсралт №1

**НЭГДМЭЛ СОНИРХОЛТОЙ ЭТГЭЭДИЙГ БҮРТГЭХ ХУУДАС**

1. Доор дурдсан хамаарал бүхий этгээдийг нэгдмэл сонирхолтой этгээдэд тооцож бүртгэнэ.
- 1.1 Эхнэр, нөхөр, тэдэнтэй хамт амьдарч байгаа гэр бүлийн бусад гишүүн; тэдгээрийн эцэг, эх, хүүхэд, ач, зээ болон ах, эгч, дүү; тэдгээр нь өөрсдийн ажиллаж байгаа болон хувьцааг нь эзэмшдэг компанитай хийгдэж байгаа хэлцлийн үр дүнгээс шууд болон шууд бусаар үүсэх орлогоос хувь хүртэж байгаа тохиолдолд;

№	Овог Нэр	Регистрийн дугаар	Ямар хамааралтай болох	Компанид хувьцаа эзэмшдэг эсэх	
				Компани нэр	Эзэмшил хувь
1					
2					

“Таван Богд Финанс ББСБ” ХХК-ийн 2024 оны 07 сарын 09-ний өдрийн  
“Сонирхлын зөрчилтэй хэлцэл байгуулах журам”-ын Хавсралт №2

**СОНИРХЛЫН ЗӨРЧИЛ МЭДЭГДЭХ ХУУДАС**

..... ХХК-ийн ..... албан тушаалтай би өөрийн болон компанийн нэрийн өмнөөс ашиг сонирхлын зөрчилтэй хэлцэл байгуулах нөхцөл байдал үүссэн тул тус журмын 2.3-т заасны дагуу мэдээлэх үүргээ хэрэгжүүлж байна. Үүнд:

.....  
.....  
.....(тус хоосон зайд ашиг сонирхлын зөрчилтэй хэлцэлд тооцогдох үндэслэлийг бичнэ. )

**Хэлцэл байгуулах мэдээлэл:**

№	Хэлцлийн нэр	Хэлцлийн нөгөө талын мэдээлэл	Хэлцлийн үнийн дүн	Хэлцлийн агуулга
1				
2				

**Мэдээлэл гаргасан:**

..... ХХК  
..... албан тушаалтай  
..... овогтой..... нэр  
Гарын үсэг.....

ББСБ нь энэхүү мэдэгдэх хуудаст заасан мэдээллийн нууцлалыг бүрэн, хугацаагүй хадгалахаа баталж байна.